



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/514

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02 тоот зөвлөмжийн дагуу дээрх барааг нийлүүлэх нийлүүлэгчээр 23 дугаар багцад шалгарсан “Энто” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Нэгдсэн эмнэлэг (М.Бямбасүрэн)-д олгосугай.

2. “Энто” ХХК-тай гэрээ байгуулж, нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг чанарын өндөр түвшинд нийлүүлэхийг “Энто” ХХК-ийн захирал (Ч.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6330010533